



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийн үйл ажиллагааны
удирдамж батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. "Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх, тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Соронзонболд)-т үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Р.СЭДДОРЖ